

Хүүхдэд зориулсан Библи танилцуулж байна

Баян хүн, Ядуу хүн



Зохиогч: Edward Hughes
Зураглаач: M. Maillot; Lazarus

Орчуулсан: Damdin Horolsuren
Найруулсан: M. Maillot; Sarah S.

Түүх 44/60

www.M1914.org

Bible for Children, PO Box 3, Winnipeg, MB R3C 2G1 Canada

Зөвшөөрөл: Та энэ бүтээлийг хувилах хуулах эрхтэй харин худалдахыг хориглоно.

Монгол хэл

Mongolian

Олон шашны удирдагч нар
Бурханыг хайрлахаасаа илүү
мөнгийг хайрлаж байгааг
Есүс мэдэж байв.



1

Тэр Бурхан байхгүй бол мөнгө
байгаад нэмэргүй гээд хоёр хүний
түүхийг ярив. Хүн баян байсан
ч Диваажинд буй Бурханаас
амь худалдан авч
чадахгүй
юм.



2

Нэгэн баян хүн байсан бөгөөд үнэтэй гоёмсог хувцас өмсдөг байв. Тэр яг л хаан шиг хувцасладаг байжээ.




3

Тэр баян хүн төрөл бүрийн амттай зоог баридаг байв. Түүний хоол унд нь найрын ширээ адил байдаг байв. Тэр маш их мөнгөтэй учир өөрийн хүссэн амттан хоол зуушийг өглөө, өдөр, оройн хоолондоо иддэг байжээ.



4

Тэр баян айлыг үүдэнд нэгэн ядуу, өвчтэй өлсгөлөн гуйлгачин эр хаалгыг нь сахин хэвтдэг байв. Түүний нэрийг Лазар гэдэг ажээ.



5

Ядуу Лазар яр шархандаа баригдсан байлаа. Тэр халдварт өвчинтэй байсан ч байж магадгүй. Бусад хүмүүс түүнийг зодож гэмтээсэн ч байж болох юм. Тэр хоол хүнс, мах, сүү, бас ногоо хангалттай идээгүйгээс өвчин туссан ч байж болох юм.



6

Лазар хоол хүлээж суудаг байлаа. Тэр баян хүний зоогийн ширээнээс өвдөл цөвдөл унахад маш их баярладаг байв.



7

Ядуу эрийг золбин ноход дагадаг байв. Тэд түүний яр шархыг долоодог байлаа. Учир нь Лазарыг асрах хэн ч байсангүй.



8

Нэгэн өглөө Лазар сэрсэнгүй. Ядуу найз нөхөдгүй өлсгөлөн Лазар энэ амьдралыг орхижээ. Тэр үхсэн байв.



9

Лазарыг үхэх агшинд түүнд зориулсан баяр хөөр эхлэв. Есүс тэнгэр элч нарт түүнийг Абрахамын өвөр дээр тавихыг тушаав. Бурхан Лазарыг тайвшруулжээ.



10

Баян хүн ч бас үхжээ. Түүний бүх хөрөнгө мөнгө нь түүний амийг аварч чадсангүй. Үхэл ирэх үед хэн ч зогсоож чадахгүй билээ.



11

Баян хүнийг оршуулжээ. Магадгүй түүний булш их том байсан байх. Хүмүүс баян эрийг магтаж ухаантай амжилттай эр гэж хэлж байсан байх. Гэвч тэдний магтаал түүнд өчүүхэн ч тус болсонгүй. Баян хүн тамд унажээ.



12

Тамаас тэр хашхирч "Абрахам Эцэгээ Лазарыг нааш нь явуулаач, би энэ галд шатаж үхлээ тэр хуруугаа усанд дүрээд миний аманд хий гэж хэлээч" гэжээ.



13

Абрахам хариуд нь "Чи амьдралынхаа туршид сайныгаа авсан харин Лазар юу ч аваагүй", гээд "Одоо чи тэнд зовж харин Лазар энд тайтгарч байна" гэв. "Чи бидний хооронд хэн ч үл очиж чадах том ангал тогтжээ" гэв.



14

"Эцэг ээ, тэгвэл түүнийг миний эцгийн гэрт илгээхийг би танаас гуйя. Би таван дүүтэй. Энэхүү тарчлалын газар тэднийг

ирүүлэхгүйн тулд Лазар тэдэнд сануулаг" гэж хэлжээ.



15

Харин Абрахам "Тэдэнд Бурханы үг байгаа шүү дээ" гэв. Хэрэв тэд Библид итгэдэггүй юм бол Лазар үхлээс амилсан ч тэд үнэмшихгүй биз дээ гэв.



16

Есүсийг баян эр болон Лазарыг тухай түүхийг ярьж дуусахад шашны удирдагч нар өөрсдөөсөө "Би мөнгыг Бурханаас илүү хайрлаж байна уу?"



17

хэмээн өөрөөсдөөсөө асуусан байх. Ингээд тэд Бурханыг үгийг сонсохгүй бол юу тохиолдох талаар мэдэж авчээ.



18

Баян хүн, Ядуу хүн

Бурханы үг Библиээс авсан түүх

Лук 16

"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг."

Дуулал 119:130

Бурхны гэм гэж нэрлэдэг муу зүйлийг бид хийдгийг Бурхан сайн мэднэ. Гэмийн шийтгэл нь үхэл юм.

Бурхан бидэнд маш их хайртай Тэрээр өөрийн хүү Есүсийг бидний гэмийн төлөөс болгон загалмайн үхэлд тушаасан. Есүс дахин амилж мөнхийн улсдаа буцсан! Одоо Бурхан бидний гэмийг уучилж чадна.

Хэрвээ та гэмээсээ эргэхийг хүсвэл, Бурханд хандан ийнхүү хэлээрэй: Бурхан минь ээ, Би Есүс миний төлөө үхээд дахин амилсан гэдэгт итгэж байна. Миний амьдралд орж ирээд миний гэмийг уучлаач тэгээд би шинэ амьдралаар амьдарч дараа нь тантай хамт мөнхөд амьдрах болно.

Таны хүүхэд шиг Таны төлөө амьдрахад туслаач.

Амен Иохан 3:16

Библи уншиж өдөр бүр Бурхантай ярилцаарай!